

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/179/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Х.Еркебулан Утас: 92921881 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
Байхгүй	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.НУРКЕН ТАНАА**

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠘ № 137
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн -Дүгнэлт

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн -Дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	348,195,082.42	341,910,790.18
33	АВЛАГА	0.00	929,895.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	929,895.00
35	БАРАА МАТЕРИАЛ	348,195,082.42	340,980,895.18
351	Түүхий эд материал	1,796,400.00	1,286,591.00
35110	Тусгай зориулалттай материал	1,070,000.00	1,070,000.00
35130	Эм боох материал	726,400.00	216,591.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	5,170,850.00	6,285,850.00
354	Хангамжийн материал	341,227,832.42	333,408,454.18
35410	Бичиг хэргийн материал	8,678,403.80	8,419,578.80
35420	Аж ахуйн материал	265,066,484.53	258,156,648.29
35430	Сэлбэг хэрэгсэл	2,350,000.00	300,000.00
35450	Барилгын засварын материал	26,354,603.89	20,944,453.89
35460	Хүнсний материал	2,921,545.20	11,730,978.20
35470	Бусад хангамжийн материал	35,856,795.00	33,856,795.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,404,597,291.30	2,323,196,954.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,404,597,291.30	2,323,196,954.16
392	Биет хөрөнгө	2,104,597,291.30	2,023,196,954.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,724,167,564.25	1,724,167,564.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-64,486,429.94	-96,468,373.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,500,000.00	69,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-52,699,999.96	-53,399,999.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,280,488,814.58	1,319,376,811.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,036,389,048.65	-1,103,825,358.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,692,675.90	245,892,675.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-164,174,462.88	-202,853,508.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,345,445.40	1,345,445.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,195,445.40	-1,195,445.40
39217	Ном	118,348,178.00	120,657,142.00
393	Биет бус хөрөнгө	300,000,000.00	300,000,000.00
39301	Програм хангамж	17,210,000.00	17,210,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-17,210,000.00	-17,210,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	300,000,000.00	300,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,752,792,373.72	2,665,107,744.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,752,792,373.72	2,665,107,744.34
51	Засгийн газрын хувь оролцоо	2,752,792,373.72	2,665,107,744.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,978,081,409.00	1,978,081,409.00
51101	Өмч: - төрийн	1,978,081,409.00	1,978,081,409.00
512	Хуримтлагдсан үр дүн	-707,159,262.09	-794,843,891.47
51210	Өмнөх үеийн үр дүн	-551,451,801.14	-707,159,262.09

51220	Тайлант үеийн үр дүн	-155,707,460.95	-87,684,629.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,481,870,226.81	1,481,870,226.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,752,792,373.72	2,665,107,744.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,120,185,436.00	2,276,772,390.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,758,500.00	3,984,729.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,758,500.00	3,984,729.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,758,500.00	3,984,729.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,272,200.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,070,000.00	1,330,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,416,300.00	1,654,729.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,113,426,936.00	2,272,787,661.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,092,606,336.00	2,272,787,661.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,075,165,400.00	2,217,590,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	17,440,936.00	55,196,961.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,820,600.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,220,600.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	600,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,268,050,036.95	2,364,457,019.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,268,050,036.95	2,364,457,019.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,061,038,987.15	2,111,470,039.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,376,325,236.00	1,435,094,067.00
210101	Үндсэн цалин	915,966,036.00	1,435,094,067.00
210102	Нэмэгдэл	315,299,400.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,430,000.00	-
210104	Урамшуулал	88,629,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,022,243.00	185,550,278.00

**Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	118,658,143.00	185,550,278.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,341,000.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,672,900.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	2,668,200.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	26,682,000.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,364,114.00	217,752,400.00
210301	Гэрэл, цахилгаан	8,194,047.00	4,781,218.00
210302	Түлш, халаалт	183,038,231.00	195,204,512.00
210303	Цэвэр, бохир ус	14,131,836.00	17,766,670.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,746,461.36	24,170,964.64
210401	Бичиг хэрэг	7,631,308.00	4,495,284.00
210402	Тээвэр, шатахуун	6,118,370.00	4,385,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,813,801.00	3,653,221.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,490,500.00	1,538,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,873,100.00	2,430,200.00
210408	Бараа материал акталсны зардал	9,819,382.36	7,667,769.64
2105	Нормативт зардал	48,199,450.00	75,342,862.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,693,050.00	1,123,028.00
210502	Хоол, хүнс	24,380,930.00	39,466,667.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,125,470.00	34,753,167.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,917,910.00	9,678,200.00
210604	Урсгал засвар	36,917,910.00	9,678,200.00
2107	Томилолт, зочны зардал	310,000.00	-
210702	Дотоод албан томилолт	310,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,772,000.00	3,525,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,164,000.00	1,141,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,020,400.00	1,980,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,600.00	166,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	158,400.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	182,000.00	79,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	177,381,572.79	160,356,267.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,341,815.00	21,558,969.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	156,039,757.79	138,797,298.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	207,011,049.80	252,986,980.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	197,389,100.00	252,784,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,102,800.00	128,695,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	143,524,300.00	121,889,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,762,000.00	2,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,621,949.80	202,180.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,621,949.80	202,180.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(147,864,600.95)	(87,684,629.38)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,842,860.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,842,860.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,842,860.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(155,707,460.95)	(87,684,629.38)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,978,081,409.00	1,481,870,226.81	-707,159,262.09	2,752,792,373.72
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,978,081,409.00	1,481,870,226.81	-707,159,262.09	2,752,792,373.72
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,978,081,409.00	1,481,870,226.81	-707,159,262.09	2,752,792,373.72
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00

Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			-87,684,629.38	-87,684,629.38
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,978,081,409.00	1,481,870,226.81	-707,159,262.09	2,752,792,373.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,098,328,200.00	2,219,920,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,342,200.00	2,330,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,342,200.00	2,330,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,342,200.00	2,330,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,272,200.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,070,000.00	1,330,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,095,986,000.00	2,217,590,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,075,165,400.00	2,217,590,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,075,165,400.00	2,217,590,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,820,600.00	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,220,600.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	600,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,093,928,200.00	2,217,720,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,093,928,200.00	2,217,720,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,886,917,150.20	1,964,733,720.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,364,475,979.00	1,429,107,840.00
210101	Үндсэн цалин	904,116,779.00	961,705,700.00
210102	Нэмэгдэл	315,299,400.00	311,829,410.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,430,000.00	57,160,960.00
210104	Урамшуулал	88,629,800.00	98,411,770.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,910,000.00	192,466,400.00
210201	Тэтгэврийн даатгал	130,545,900.00	139,102,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,341,000.00	13,341,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,672,900.00	10,672,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,668,200.00	2,668,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,682,000.00	26,682,100.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,670,114.00	217,752,400.00
210301	Гэрэл, цахилгаан	8,194,047.00	4,781,218.00
210302	Түлш, халаалт	183,344,231.00	195,204,512.00
210303	Цэвэр, бохир ус	14,131,836.00	17,766,670.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,684,471.00	15,442,390.00
210401	Бичиг хэрэг	2,597,500.00	2,539,700.00
210402	Тээвэр, шатахуун	5,778,370.00	4,385,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,828,801.00	3,653,221.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,936,000.00	2,788,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,543,800.00	2,074,979.00
2105	Нормативт зардал	29,820,986.20	53,480,959.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,995,050.00	355,000.00
210502	Хоол, хүнс	21,066,736.20	49,945,959.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,759,200.00	3,180,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,080,000.00	4,160,000.00
210604	Урсгал засвар	12,080,000.00	4,160,000.00
2107	Томилолт, зочны зардал	310,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	310,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,772,000.00	3,525,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,164,000.00	1,141,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,020,400.00	1,980,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,600.00	166,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	158,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	182,000.00	79,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,193,600.00	48,798,731.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,193,600.00	48,798,731.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	207,011,049.80	252,986,980.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	197,389,100.00	252,784,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,102,800.00	128,695,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	143,524,300.00	121,889,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,762,000.00	2,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,621,949.80	202,180.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,621,949.80	202,180.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,400,000.00	2,200,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,400,000.00	2,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,400,000.00	2,200,000.00

2200	Дотоод эх үүсвэрээр	4,400,000.00	2,200,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,400,000.00	2,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4,400,000.00	-2,200,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,221,090,700	2,219,718,520
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,221,090,700	2,219,718,520
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,968,296,300	1,966,933,720
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,429,225,000	1,429,107,840
210101	Үндсэн цалин	968,865,800	961,705,700
210102	Нэмэгдэл	315,299,400	311,829,410
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,430,000	57,160,960
210104	Урамшуулал	88,629,800	98,411,770
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,466,400	192,466,400
210201	Тэтгэврийн даатгал	139,102,300	139,102,300
210202	Тэтгэмжийн даатгал	13,341,000	13,341,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,672,800	10,672,800
210204	Ажилгүйдлийн даатгал	2,668,200	2,668,200
210205	Эрүүл мэндийн даатгал	26,682,100	26,682,100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,752,400	217,752,400
210301	Гэрэл, цахилгаан	8,476,700	4,781,218
210302	Түлш, халаалт	195,204,500	195,204,512
210303	Цэвэр, бохир ус	14,071,200	17,766,670
2104	Хангамж, бараа материалын зардал	15,463,300	15,442,390
210401	Бичиг хэрэг	2,145,000	2,539,700
210402	Тээвэр, шатахуун	4,406,700	4,385,790
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,859,600	3,653,221
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,788,700	2,788,700
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,263,300	2,074,979
2105	Нормативт зардал	53,803,200	53,480,959

Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	493,600	355,000
210502	Хоол, хүнс	50,129,600	49,945,959
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,180,000	3,180,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,160,000	4,160,000
210604	Урсгал засвар	4,160,000	4,160,000
2107	Томилолт, зочны зардал	128,000	0
210702	Дотоод албан томилолт	128,000	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,679,000	3,525,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000	1,141,000
210803	Даатгалын үйлчилгээ	1,980,000	1,980,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	166,100	166,100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,400	158,400
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	174,500	79,500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,619,000	50,998,731
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,619,000	50,998,731
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	252,794,400	252,784,800
2132	Бусад урсгал шилжүүлэг	252,794,400	252,784,800
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,695,200	128,695,200
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	121,889,600	121,889,600
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,209,600	2,200,000
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,221,090,700	2,219,718,520
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,217,590,700	2,217,388,520
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,217,590,700	2,217,388,520
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,500,000	2,330,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000	2,150,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000	180,000
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	127	127
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	80	80
620003	Үйлчлэх ажилтан	40	40
620004	Гэрээт ажилтан	6	6
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1	1
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	1	1
632001	Төрийн өмчит МСҮТ	1	1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	127	127
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	91	91
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30	30

650010	Гэрээт ажилтан	6	6
--------	----------------	---	---

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Хөдөлмөрийн зах зээлийн эргэлтэн нийцсэн, ажил олгогчийн шаардлагыг хангасан, чадварлаг орлоготой ажилтан бэлтгэнэ.

Стандартыг хангасан сургуулийн орчин бүрдүүлж, Политехникийн коллеж болох. Зөв хандлага, эерэг төлөвшилтэй төгсөгч бэлтгэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын комисс ажилладаг. Тус комисс нь байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, алба, салбар нэгжийн үйл ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгаж, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, анги, байгууллагын тодорхойлсон эрсдэлийг нэгтгэн, байгууллагын эрсдэлийн үнэлгээг тогтоож, тайланг ХНХЯамны дотоод хяналт шалгалтын хэлтэст хүргүүлдэг байна.

Тус газарт 2021 онд дотоод аудитын шалгалт ирээгүй бусад эрх бүхий байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2268.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 34.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 23.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 87.6 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	929.9	929.9
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	348195.1	340980.9	-7214.2
Үндсэн хөрөнгө	2404597.3	2323196.9	-81400.4
Нийт хөрөнгө	2752792.4	2665107.7	-87684.7

Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<u>2752792.4</u>	<u>2665107.7</u>	<u>-87684.7</u>
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>2752792.4</u>	<u>2665107.7</u>	<u>-87684.7</u>

Мөнгөн хөрөнгө оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй ба оны эцэст 0.9 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 340.9 сая төгрөг болж 7.2 сая төгрөгөөр буурчээ. Тайлант онд 117.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 0.5 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 117.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 7.7 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2323.2 сая төгрөг болж 81.4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 2.2 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй 55.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, үндсэн хөрөнгөнд 138.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2665.1 сая төгрөг болж 87.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -87.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2276.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 156.6 сая төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 96.5 сая төгрөгөөр буюу 4.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглахтай холбоотой зардал, норматив зардал, бусад урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглахтай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, норматив зардал, бусад урсгал шилжүүлэг зардлууд өмнөх оноос нэмэгдэж, хангамжийн бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 2128.7 сая төгрөг, тодотгосон төсөв 2221.1 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 92.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 95.1 сая төгрөгөөр, НДШ-ийг 12.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хоолны зардлыг 44.6 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Хүүхдийн тоо өссөнтэй холбоотой багшийн тоо өссөн тул цалингийн зардлыг нэмж зохицуулалт хийжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2217.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 2217.4 сая төгрөгийг зарцуулж, 0.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Энэ нь үндсэн цалин, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын хэмнэлт байна.

Нийт төсвийн 64.3 хувийг цалин, 8.7 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 9.8 хувийг байр ашиглалтын зардал, 0.7 хувийг хангамж бараа материалын зардал, 2.4 хувийг норматив зардал, 0.2 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 2.3 хувийг бараа материалын зардал, 11.4 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 4.9 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 2.2 сая төгрөгийн тавилга худалдан авч Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2021 онд нийт 2217.6 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2217.6 сая төгрөгийн 119 мэдээллийг хугацаандаа байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 268.4 сая төгрөгийн 12 гүйлгээ гарсныг мэдээлэлцсэн боловч мөнгөн дүнгээ бичээгүй, тэтгэмжийн зардалтай холбоотой нийт 195.2 сая төгрөгийн 8 гүйлгээ гарсныг бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 282.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 14.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 268.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

1. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 2217.4 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтын дагуу байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсөв 49.7 сая төгрөгийн 10 хувь 4.9 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 2.2 сая төгрөгийн тавилга худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байранд 2021 оны 9-12 дугаар сард байрлаж байсан 9672 хүүхдэд төвийн захирлын хянаж баталсан хоолны талоны дүнгээр гүйцэтгэлээр нийтдээ 36.4 сая төгрөгийн хүнсний материал зарцуулж, дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны нормоор тооцоход жилийн дүнгээр 7.4 сая төгрөгөөр хэтрүүлэн төсвөөс хууль бус зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийг дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Засгийн газрын 2020 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Хоолны зардлын норматив тогтоох тухай” журмын 1-т “Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 3000 (гурван мянган) төгрөгөөр тогтоосугай” гэсэн заалтуудыг тус тус зөрчжээ.

Шийдвэрлэсэн нь: Дотуур байрны хүүхдийн хоолны батлагдсан нормыг баримталж зөрчлийг давтан гаргахгүй байхыг албан шаардлага болгов.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн данстай холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгөв. Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 268.4 сая төгрөгийн 12 гүйлгээ гарсныг мэдээлээгүй орхигдуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш гүйлгээг бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	3	282.9					2	14.5	1	268.4
	Нийт дүн	3	282.9					2	14.5	1	268.4